

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

### Аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.18, 9.2 дахь заалт, “Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 494 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал”-ын 1 дүгээр зүйлийн 1.5-д “... эрхлэх хугацаа,” гэсний дараа “үйлчлэх хүрээний нэмэгдсэн хэмжээ,” гэж; 3 дугаар зүйлийн 3.2-д “...хөлсний” гэсний дараа “тооцоолсон” гэж тус тус нэмсүгэй.

2. Дээрх аргачлалд дор дурдсан заалтуудыг нэмсүгэй.

2.1 Тус аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.6-д “Хороо нь Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх тухай гэрээ байгуулна.” ;

2.2 2 дугаар зүйлийн 2.4-д “Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлэхэд:

$$T_{нд} = C + C_{нд} \cdot 0.86 \times T_{хч}$$

$T_{нд}$  - Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

$C$  - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг;

$C_{нд}$  - Үйлчлэх хүрээнд нэмэгдсэн дулааны тооцоот ачааллын хэмжээ; Гкал/ц;

$T_{хч}$  - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

2.3 2 дугаар зүйлийн 2.5-д “Цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлэхэд:

$$T_{нц} = C + C_{нц} \times T_{хч}$$

$T_{нц}$  - Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

$C$  - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг;

$C_{нц}$  - Үйлчлэх хүрээнд нэмэгдсэн хүчин чадлын хэмжээ; МВт;

$T_{хч}$  - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

2.4 2 дугаар зүйлийн 2.8-д “Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх тухай гэрээг байгуулах ажлыг Хуулийн асуудал хариуцсан нэгж хариуцан зохион байгуулна.” ;

3. Дээрх аргачлалын 2 дугаар зүйлийн “2.4” гэснийг “2.6” гэж; 2 дугаар зүйлийн “2.5” гэснийг “2.7” гэж; 2.5-д “гарвал Хорооны тогтоолыг үндэслэн, ажлын 3 хоногийн дотор” гэснийг “гарсан өдөр” гэж; 2.5-д “санхүүд” гэснийг “Захиргаа, удирдлагын газарт” гэж; 2 дугаар зүйлийн “2.6” гэснийг “2.9” гэж; 2.6-д “... Санхүү” гэснийг “Хорооны нягтлан бодогч” гэж; 3.2-д “...өмнөх” гэснийг “тухайн” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (А.Айдос)-т даалгасугай.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ

ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ

ЗОХИЦУУЛАГЧ

Д.ЦОГОО